

Ургацын баярын үеэр ‘нийгмийн харилцаанд зай барих’ түвшинд хийх зохицуулалт

Нийгмийн харилцаанд зай барих түвшинд хийх зохицуулалт, төлөвлөгөө ~ 10.3 хүртэл (Ням)

Ангилал		4-р үе шат	3-р үе шат
Түвшинд шилжих нөхцөл		* Сөүл 389, Кёнги 537, Инчон 118, нийслэл орчмын бүс нутаг 1000 гаруй	Долоо хоногийн нэг өдөрт 100 мянган хүн тутамд дунджаар 2 ба түүнээс дээш хүн * Тэжон 30, Сэжун 7, Чүнбүк 32, Чүннам 42, Гуанжү 29, Жонбүк 36, Жоннам 37, Дэгү 49, Кёнгбүк 53, Бүсань 68, Үлсан 23, Гённам 67, Ганвонь 31, Жэжү 13 ба түүнээс дээш
		* Нийслэлийн бүс бүс нутаг 100 мянгаас доош хүн амтай хот · сумд бие даан түвшний зохицуулалт хийнэ.	
Хувийн уулзалт		18:00 цагаас өмнө 4 хүртэл хүн 18:00 цагаас хойш 2 хүртэл хүн * Вакцин хийлгэсэн хүмүүс ресторан, кафе болон гэртээ 6 хүртэл хүний хувийн уулзалт хийх боломжтой.	4 хүртэл хүн * Вакцин хийлгэсэн тохиолдолд 8 хүртэлх хүн хувийн уулзалт хийх боломжтой.
Олон нийтийн байгуулалт	Цугларахыг хориглоно	Зугаа цэнгээний газар, дуулдаг уушийн газар, диско клуб, бүжиглэдэг, танилцдаг уушийн газрууд, тоглоомын газрууд гэх мэт	-
	22 цагаас хойш үйл ажиллагаанд хязгаарлалт тавина	Кароке бар, хоолны газар · кафе*, спорт заал, кино театр, РС, дамжаа зэрэг 1 ~ 3 бүлэг (цуглуулахыг хориглосноос бусад төрөл бүрийн зориулалттай бүх байгуулалт) * Ресторан, кафегаар үйлчлүүлэхдээ вакцин хийлгэсэн хүмүүсийг (4 хүртэлх хүн) оролцуулан 6 хүртэлх хүнтэй хувийн цугларалт хийх боломжтой (22:00 цаг хүртэл)	Зугаа цэнгээний газар, покер тоглоомын газар, бүжиглэдэг мөн танилцдаг уушийн газрууд, дуу дуулдаг газар, хоолны газар-кафе, сауна, бассейн, очиж худалдан авалт болон борлуулалт хийх зорилгоор шууд худалдаа хийх сурталчилгааны танхим * Олон нийтийн байгуулалтаар үйлчлүүлэхдээ вакцинжуулалтад хамрагдсан хүнийг оролцуулан 8 хүртэлх хүн хувийн уулзалт хийх боломжтой (улсын хэмжээнд ижил)
Арга хэмжээний уулзалт		Арга хэмжээг хориглох, нэг хүний жагсаалаас бусад уулзалт цуглааныг хориглох	50-с дээш хүнтэй арга хэмжээ зохион байгуулах болон цуглахыг хориглох
Спортын уралдаан тэмцээн (үзэх)		Үзэгчгүй	(дотор) хүлээн авах боломжтой хүний тооны 20% (гадаа) хүлээн авах боломжтой хүний тооны 30%
Хуримын ордон		Хуримын ёслолд 49 хүртэл хүн оролцохыг зөвшөөрөх * Хуримын зоог барихгүй тохиолдолд 99 хүртэл хүн оролцохыг зөвшөөрөх	
Шашны үйл ажиллагаа		Хүлээн авах боломжтой хүний тооны 10%, хамгийн ихдээ 99 хүн хүртэл хүлээн авахыг зөвшөөрөх, Уулзалт/арга хэмжээ · хооллох · хоноглохыг хориглох	Хүлээн авах боломжтой хүний тооны 20%, Уулзалт/арга хэмжээ · хооллох · хоноглохыг хориглох (гадаа) арга хэмжээ 50 хүртэлх хүн оролцохыг зөвшөөрөх

- Ургацын баярын үед халдварт өвчнөөс сэргийлэх тусгай арга хэмжээ, 9.17 (баасан) ~ 9.26 (ням)
- Гэр бүлийн уулзалт: Гэр бүлийн вакцины бүрэн тунгаа хийлгэсэн хүмүүсийг оролцуулаад 8 хүртэлх хүн уулзах боломжтой (вакцин хийлгэсэн хүн байхгүй тохиолдолд 4 хүн хүртэлх)
- Зам тээвэр: Төмөр замын хувьд зөвхөн цонхон талын суудлыг борлуулах, хурдны замын хураамжийг энгийн үеийн горимоор авах, хурдны зам дагуу байрлах түр амрах газруудад хооллохыг хориглох, далайн эргийн зорчигч тээврийн хөлөг онгоцны багтаамжийн 50% -ийг ашиглах
- Эргэлт : Сувилахуйн эмнэлэг, байгууламжийн урьдчилсан захиалгын системийг нэвтрүүлэх (шууд уулзах эргэлтийн үед эмчлүүлэгч болон эргэн ирж буй хүн аль аль нь вакцин хийлгэсэн байх)

<Энэ орчуулгыг Данури төв 1577-1366 хийсэн болно>